

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН ГАЗАР

Аудит хийгдэх байгууллага:

“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ

ГҮЙЦЭТГЭЛ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын нэр: “БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ын
2018 оны үйл ажиллагаанд хийх дотоод аудит, хяналт шалгалт

2019 он

ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛ

Нийслэлийн Засаг даргын баталсан 16 дугаар удирдамж, нийслэлийн Дотоод аудитын газрын 2019 оны аудитын жилийн төлөвлөгөөний дагуу “Багануур үйлдвэрлэл технологийн парк” ОНӨТҮГ-ын 2018 оны үйл ажиллагаанд 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрөөс 2019 оны 07 дугаар сарын 08-ны өдрийг дуустал хугацаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Дотоод аудит, хяналт шалгалтаар илэрсэн асуудлын талаар:

Аудитын багаас “Хэдийгээр хяналтын орчин зохистой боловч зарим хяналттай холбоотой алдаа зөрчил, асуудал илэрсэн” үед олгогддог “САЙЖРУУЛ/АЛТ ХЭРЭГТЭЙ” үнэлгээ, нийт 7 зөвлөмж өгч ажиллав.

1. Байгууллагын засаглалын үйл явцыг үнэлэн, сайжруулах зөвлөмж өгөх зорилтын хүрээнд:

Дүрэмд тус газрыг тодорхойлохдоо “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” зорилтын хүрээнд дүрмээр хүлээсэн үүргийн зарим хэрэгжилт хангалтгүй, стратегийн төлөвлөгөө батлуулаагүй, захирлын зөвлөлийн хурлын тэмдэглэлийг бүрэн хөтлөөгүй, ажлын байрны тодорхойлолтод заасан үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй зэрэг асуудлууд илэрлээ.

2. Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашгийн байдалд дүгнэлт, зөвлөмж өгөх

• Тус байгууллага тайлант хугацаанд 4,962,660 төгрөгөөр эргэлтийн цэг суулгаж тэмдэгжүүлэх ажлыг гүйцэтгээд тэмдэг тэмдэглэгээг хөрөнгөөр бүртгээгүй, гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6.4.1. “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”; НББ-ийн тухай хуулийн 5.1.4. “үнэн зөв байх”; Төсвийн тухай хуулийн 6.3.2. “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах” гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй хангалтгүй.

• Тус байгууллага 2018 онд “Тогосын хөндий” ХХК-аар нийт 19,114,960 төгрөгийн бараа, ажил үйлчилгээ гүйцэтгүүлж, төлбөрийг шилжүүлэхдээ ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8.1.2.-т “...шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”; 8.7.1.-т “тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгох” гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй.

3. Төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа үйл ажиллагаа болон төсвийн санхүүжилт, түүний үр ашигтай байдалд дүгнэлт, зөвлөмж өгөх /шаардлагатай тохиолдолд санхүүгийн хяналт шалгалтын үлсын байцаагчийн акт, албан шаардлага хүргүүлэх/:

- “Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх” 2,998,900 зардлаас “Шинэ санаагаа оюуны өмчөөр баталгаажуулж хөрөнгө болгоё” сэдэвт сургалт зохион байгуулж 16 байгууллагыг хамруулан ажлуулсан байна.
- Жолоочийн замын хуудсыг хэрэглэж байгаа боловч тухайн хуудсын үндсэн үзүүлэлт болох спидометрийн заалтыг тусгаагүй байна.

1. ТАНИЛЦУУЛГА

“Багануур үйлдвэрлэл технологийн парк” ОНӨТҮГ нь НИТХТ-ийн 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 122 дугаар тогтоолоор үүсгэн байгуулж, дүрмийг 11 бүлэг 43 зүйлтэйгээр тогтоосон.

НЗД-ын 2016 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/757 дугаар захирамжаар тус газрын орон тооны дээд хязгаарыг 14 байхаар баталсан байна.

Аудит, хяналт шалгалтын хамрах хугацаанд 14 албан хаагчтай ажиллаж байна.

Тус газрын эд хөрөнгийн эрхийн байдлыг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд ОНӨААТҮГ, дүрмийн 1.1-т “...газар нь Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртлэх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг, нийслэлийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн нутаг дэвсгэрт парк байгуулах бэлтгэл ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий газар /ОНӨААТҮГ / мөн.” гэж тодорхойлсон.

Тус байгууллага нь 2714001005 тоот улсын бүртгэлийн дугаартай, НЗД-ын 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн Б/324 дугаар захирамжаар Ч.Элбэгсайханыг “Багануур үйлдвэрлэл технологийн парк” ОНӨААТҮГ-ын даргаар, “Багануур үйлдвэрлэл технологийн парк” ОНӨААТҮГ-ын даргын 2015 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн Б/02 дугаар тушаалаар Л.Оюунцэцэг нягтлан бодогчоор тус тус томилон ажиллуулсан байна.

Төрийн сан банканд харилцахын үндсэн 100200051097 тоот данстай ба нэгдүгээр гарын үсгийг “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨААТҮГ-ын дарга Ч.Элбэгсайхан, хоёрдугаар гарын үсгийг ерөнхий нягтлан бодогч Л.Оюунцэцэг зурдаг. НАГ-аас газраас 2018 оны санхүүгийн тайланд аудит хийж “Зөрчилгүй” санал дүгнэлт хүргүүлжээ.

2. АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

“Багануур үйлдвэрлэл технологийн парк” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа нь хууль, тогтоомж, НЗД-ын баталсан захирамж, холбогдох журам, заавар, шийдвэртэй нийцэж буй эсэхэд дүгнэлт өгөхөд чиглэнэ.

Аудитын удирдамжийн зорилгыг хангахад дараах зорилтуудыг хэрэгжүүллээ.

Үүнд:

1. Байгууллагын засаглалын үйл явцыг үнэлэн, сайжруулах зөвлөмж өгөх;
2. Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашгийн байдалд дүгнэлт, зөвлөмж өгөх;

3. Төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа үйл ажиллагаа болон төсвийн санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашигтай байдалд дүгнэлт, зөвлөмж өгөх.

2.2. АУДИТЫН ЦАР ХҮРЭЭ

Дотоод аудитын олон улсын стандартын дагуу байгууллагын удирдлага, холбогдох албан тушаалтнуудаас лавлагаа, тодруулга, ярилцлага авах, түүвэрлэх, тулган баталгаажуулах, дүгнэлт, зөвлөмжид дэмжлэг болох нотлох баримт, мэдээ мэдээлэл, судалгааг гаргуулан гүйцэтгэв. Тухайлбал:

- ❖ Газрын дүрмийг НИТХТ-ын 2015 оны 122 дугаар тогтоолоор баталсан;
- ❖ Газар, хэлтсийн үйл ажиллагааны тайлан, түүний биелэлт;
- ❖ Ажилтан, албан хаагчдын үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээ болон ажлын байрны тодорхойлолтууд;
- ❖ Хөдөлмөрийн дотоод журам;
- ❖ 2018 оны санхүүгийн тайлан, баланс;
- ❖ Үндсэн хөрөнгө, бараа материалын тайлангууд гэх мэт бусад холбогдох материалууд.

Аудитын тайлан дахь тоон дүн мянган төгрөгөөр илэрхийлэгдсэн болно.

Аудитад хамрагдахгүй хэсэг:

Албан хаагчдын ажлын байрны зураг авалт, 2018 онд хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалт, хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөлт, НТАГ-ын санхүүгийн аудитын тайланд дурдсан асуудлууд зэргийг хамруулаагүй болно.

3. АУДИТЫН ҮР ДҮН

3.1. Илэрсэн асуудлууд

Зорилт 3.1.1. Байгууллагын засаглалын үйл явцыг үнэлэн, сайжруулах зөвлөмж өгөх;

Шалгуур:

- Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуулиуд;
- НЗД-ын захирамжийн болон дээд газрын тогтоол шийдвэрүүд;
- Дүрэм, журмаар хүлээсэн эрх, үүрэг.

Бодит нөхцөл байдал:

Дүрмээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн талаар:

НИТХТ-ын “Багануур үйлдвэрлэл технологийн парк” ОНӨТҮГ нь НИТХТ-ийн 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 122 дугаар тогтоолоор үүсгэн байгуулж, дүрмийг

баталсан ба одоог хүртэл дээрх дүрмийг мөрдөн ажиллаж байна. Дүрэмд 11 чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллахаар тогтоосон байна. Стратегийн төлөвлөгөө боловсруулан, зөвхөн инженерийн тооцоо зураглал боловсруулан ажиллах талаар дүрэмд тусгасан нь тус байгууллагын үйл ажиллагаа нь цаашид үргэлжлэхгүй мэт тодорхойлогдсон боловч паркийн удирдлагууд “Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай” хуулийг шинэчлэх, паркийн хөрөнгө оруулалтын тогтвортой байдлыг хангах зэрэг асуудлыг шийдвэрлэх санаачлагыг гарган ажилласан байна. Дүрэмд дурдсан зарим нэг байгууллагын нэр нэршил, чиг үүрэг өөрчлөгдсөн байх тул байгууллагын дүрэм эрх зүйн зөрчилтэй байна.

Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын талаар:

Газрын даргын 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/17 дугаар тушаалаар “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын Хөдөлмөрийн дотоод журмыг баталсан ба тус журам нь 16 бүлэг 73 зүйлтэй одоо хүртэл даган мөрдөж байна.

- Хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгох үндэслэл хэсэгт 4.3.2 “Ажил олгогч иргэн, ажилтан нас барсан” гэсэн заалт оруулсан байна. Ажил олгогч нас барсан тохиолдолд түүнтэй байгуулсан ажилтнуудын хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгох үндэслэл болохгүй;
- Хөдөлмөрийн хуульд тухайлан заасан заалтуудыг хөдөлмөрийн дотоод журамд дурдах нь илүүц юм.

Даргын зөвлөлийн хурлаас өгсөн үүрэг даалгавар түүнийг хэрэгжилтийн талаар:

Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 2.2.1-д “Даргын зөвлөл нь улиралд 1-ээс доошгүй удаа хуралдаж төлөвлөгөөт сонсгол, мэдээлэл, тухайн цаг үеийн тулгамдсан асуудал, сахилга, хариуцлагын тухай хэлэлцэж шийдвэрлэнэ.” гэж заасан боловч 2018 оны эхний хагас жилд 1 удаа хуралдсан байна.

Стратеги төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөөний талаар:

Тус газар даргын 2017 оны 12 дугаар сарын 28 өдрийн А/36 тушаалаар 2017-2020 стратеги төлөвлөгөөг батлан ажиллаж байна. Стратегийн төлөвлөгөөг 15 бүлэгтэй баталсан ба гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхээр “Багануур үйлдвэрлэл технологийн парк”-ийн үндсэн үйл ажиллагааны чиглэлийг тогтоосон.

Тушаал, шийдвэрийн талаар:

Байгууллагын хэмжээнд 2018 онд А тушаал 40, Б тушаал 11 тус тус гарсан байна.

- Байгууллагын даргын 2018 оны А/01 дүгээр тушаал нь НЗД-ын 2016 оны А/757 дугаар захирамжийг үндэслэн гарсан боловч албан тушаалыг өөрөөр тогтоосон.

НЗД-ын 2016 оны А/757 дугаар захирамж		2018 оны А/01 дугаар тушаал	
		Захиргааны алба	
1	Дарга	1	Дарга
2	Ахлах мэргэжилтэн	1	Хүний нөөц, гадаад харилцаа,
			1

			архив, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн	
3	Дэд бүтэц хариуцсан инженер	1	Нягтлан бодогч	1
4	Судалгаа хөгжил хариуцсан инженер	1	Хуулийн зөвлөх	1
5	Парк ашиглалтын инженер	1	Маркетинг, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн	1
6	Эдийн засагч	1	Бүртгэл мэдээлэл, программ хангамж хариуцсан мэргэжилтэн	1
7	Хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн мэргэжилтэн	1	Жолооч	1
8	Нөөцийн судалгаа, инноваци хариуцсан мэргэжилтэн		Нярав, аж ахуйн ажилтан	1
			Үйлдвэрлэл, технологийн алба	
9	Хуулийн зөвлөх	1	Ахлах мэргэжилтэн	1
10	Гадаад харилцаа, Сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн	1	Судалгаа хөгжил, инноваци хариуцсан мэргэжилтэн	1
11	Бүртгэл мэдээлэл, программ хангамж хариуцсан мэргэжилтэн	1	Эдийн засагч, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн	1
12	Хүний нөөц, бичиг хэрэг, архивын ажилтан	1	Хөрөнгө оруулалт, олон нийттэй харилцах харилцаа хариуцсан	1
13	Нягтлан бодогч	1	Дэд бүтэц хариуцсан инженер	1
14	Жолооч, нярав	1	Парк ашиглалтын инженер	1
	бүгд	14		14

Дотоод хяналтын талаар:

2015 оны 12 дугаар сарын 22-ний өдрийн Б/112 дугаар "Дотоод хяналт шалгалтын журам батлах тухай" тушаал, дотоод хяналт шалгалтын комиссыг Хүний нөөцийн мэргэжилтэн, Аж ахуйн дарга, нярав, нэгжүүдийн үйлчлэл, зах зээлийн судалгаа хариуцсан ажилтан нарын бүрэлдэхүүнтэй байхаар баталжээ. Тус журам нь 6 бүлэг 22 зүйлтэй тогтоож, Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагааг дараах байдлаар чиглэлээр журамласан байна. Үүнд:

5.1 Хууль тогтоомж, тогтоол шийдвэр болон байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэд тавих хяналт шалгалт;

5.2 Албан хаагчдын ажлын гүйцэтгэлд тавих хяналт шалгалт;

5.3 Хөдөлмөрийн дотоод журмын биелэлтэд тавих хяналт шалгалт;

5.4 Өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт;

5.5 Үйл ажиллагааны онцлогоос хамааран бусад хяналт шалгалт Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагааг 2018 онд дараах чиглэлүүдээр зохион байгуулжээ.

✓ Дээд газраас ирсэн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг байгууллагын албан хаагчдад танилцуулах, хэрэгжилтэд тавих хяналт шалгалт хийх;

✓ Байгууллагын албан хаагчдын сарын төлөвлөгөө тайлан нь байгууллагын жилийн төлөвлөгөө болон удирдлагаас өгсөн үүрэг даалгавартай нийцэх эсэх, түүний гүйцэтгэлд тавих хяналт шалгалт хийх;

- ✓ Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтэд тавих хяналт шалгалтыг хийх;
- ✓ Байгууллагад мөрдөгдөж буй дүрэм журам, стандартыг боловсронгуй болгох судалгаа хийж дүгнэлт гаргах;
- ✓ Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн шалтгаан нөхцөлийг тодруулах;
- ✓ Шаардлагатай тохиолдолд зөрчил гаргасан албан хаагчдад хариуцлага ногдуулах талаар удирдлагад санал дэвшүүлэх;
- ✓ Дотоод хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар арга зүйн зөвлөгөө өгөх;
- ✓ Дотоод хяналт шалгалтын бүртгэл хөтлөх зэрэг чиглэлээр төлөвлөгөөнд тусган ажиллажээ.

Хүний нөөцийн бодлого, нөөцийн хуваарилалт, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтын талаар:

НЗД-ын 2016 оны 10 дугаар сарын 27-ний өдрийн А/757 дугаар захирамжаар бүтэц, орон тоог 14 байхаар тогтоож өгсөн.

Хүний нөөцийн хөтөлбөрийг 2018 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр батлан хэрэгжүүлж, биелэлтийг гарган ажилласан байна.

Шалтгаан:

- “Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна;
- Хөдөлмөрийн дотоод журмыг даргын зөвлөлөөр хэлэлцэж батлаагүй;
- Дотоод хяналт, шалгалтын комиссын бүрэлдэхүүнийг баталсан тушаалд дурдсан албан тушаалын нэр өөрчлөгдсөн байгаа зэргээс **тус тус шалтгаалжээ.**

Үр нөлөө:

- Холбогдох хууль, тогтоомжийн мөрдөгдөхгүй байх;
- Дотоод эрсдэлээ урьдчилан харах боломжгүй болох;
- Ажлын хариуцлага сулрах **эрсдэлийг үүсгэсэн.**

Зорилт 3.1.2. Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашгийн байдалд дүгнэлт, зөвлөмж өгөх;

Шалгуур:

- а. Төсвийн тухай, ТБОНӨТ, НББ-ийн тухай хуулиуд;
- б. НИТХТ-дийн 2014 оны 66 дугаар тогтоол;
- в. Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журам.

Бодит нөхцөл байдал:

Тус байгууллагыг хөрөнгийн хувьд авч үзвэл 2018 онд Сонато 7 маркийн 68-88 БРА дугаартай 19,183,500 төгрөгийн автомашинтай, 16,935,474 төгрөгийн програм хангамжтай, 77,246,400,000 төгрөгийн газартай ажилласан байна. 2018 онд нэмэгдсэн үндсэн хөрөнгүүдийг доор харуулав.

2018 онд нэмэгдсэн хөрөнгө

Хөрөнгийн нэр	Дүн	Тайлбар
Програм хангамж	15,695,474	Худалдан авсан
Бусад	77,246,400,000	Бусад
Дүн	77,262,095,474	

Дээрх 15,695,474 төгрөгийн хөрөнгийн задаргааг авч үзвэл:

Хөрөнгийн нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
Газрын хянан баталгааны тайлан, зураглал	1	9000000	9,000,000.
НБББББичиг	1	3700000	3,700,000
Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ	1	2995474	2,995,474
Дүн			15,695,474

Дээрх хөрөнгөдийг дараах байдлаар олж бэлтгэсэн байна. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийлгэхээр "САТУ" ХХК-тай 9,800,000 төгрөгөөр ажил гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж урьдчилгаа 2,995,474 төгрөгийг олгосон, мөн НБББББичигийг 3,700,000 төгрөгөөр /Вестгэйт универсал консалтинг ХХК-аар 2018.06.04-ны өдөр гэрээ байгуулан /, 414 га газартай үүнд "Гранд-Амур" ХХК-аар "Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа"-г 9,000,000 төгрөгөөр гэрээ байгуулан гаргуулсан байна.

Мөн 4,962,660 төгрөгөөр эргэлтийн цэг суулгаж тэмдэгжүүлсэн байна. Тус ажлыг гүйцэтгэхдээ шаардагдах материалыг "Тогосын хөндий" ХХК-аар гүйцэтгүүлсэн боловч тэмдэг тэмдэглэгээг хөрөнгөөр бүртгээгүй, гэрээ байгуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; НББ-ийн тухай хуулийн 5.1.4. "үнэн зөв байх"; Төсвийн тухай хуулийн 6.3.2."санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах" гэсэн заалтуудын хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

Тайлант хугацаанд нэмэгдсэн хөрөнгө

Хөрөнгийн нэр	Газрын нэр	Кадастрын дугаар	Тоо хэмжээ /м2/	Нэгжийн үнэ	Нийт үнэ
Газар-1	Бордооны үйлдвэр	18299290968050	363,000	16000	5,808,000,000

Газар-2	Нүүрс боловсруулах үйлдвэр	18299290968050	972,000	16000	15,552,000,000
Газар-3	Хөнгөн хүнсний үйлдвэр	18301295034412	1,186,000	20800	24,668,800,000
Газар-4	Ургамалын генефонд, биотехнологийн үйлдвэр	18305295154001	512,000	16000	8,192,000,000
Газар-5	Барилгын материалын үйлдвэр	18303293056657	1,000,000	20800	20,800,000,000
Газар-6	Нанобиотехнологийн үйлдвэр	18302295769493	107,000	20800	2,225,600,000
Нийт дүн					77,246,400,000

Тус газрын 107,000 м²-ийг Монхимо ХХК эзэмшин эмийн ургамал тариалж байна. Тус газрыг 2018 онд дахин үнэлгээгээний журмын дагуу үнэлэн данс бүртгэлд бүртгэсэн байна.

Тус байгууллага 2018 онд "Тогосын хөндий" ХХК-аар нийт 19,114,960 төгрөгийн бараа, ажил үйлчилгээ гүйцэтгүүлж төлбөрийг шилжүүлсэн байна. Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8.1.2.-т "...шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"; 8.7.1.-т "тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгох" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шалтгаан:

- Тус байгууллага 4,962,660 төгрөгөөр эргэлтийн цэг суулгаж тэмдэгжүүлсэн байна. Тус ажлыг "Тогосын хөндий" ХХК-аар гүйцэтгүүлж ажилласан боловч тэмдэг тэмдэглэгээг хөрөнгөөр бүртгээгүй, гэрээ байгуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; НББ-ийн тухай хуулийн 5.1.4. "үнэн зөв байх"; Төсвийн тухай хуулийн 6.3.2."санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах" гэсэн заалтуудын хэрэгжилт хангалтгүй байна.
- Тус байгууллага 2018 онд "Тогосын хөндий" ХХК-аар нийт 19,114,960 төгрөгийн бараа, ажил үйлчилгээ гүйцэтгүүлж төлбөрийг шилжүүлсэн байна. Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8.1.2.-т "...шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"; 8.7.1.-т "тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгох" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Үр нөлөө:

- Хөрөнгө бүртгэгдэхгүй үргүй зарцуулагдах эрсдэл үүссэн;
- Худалдан авах ажиллагаа хууль бусаар зохион байгуулагдаж, төсвийн хөрөнгө үргүйдэх эрсдэлтэй.

Зорилт 3.1.3. Төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа үйл ажиллагаа болон төсвийн санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашигтай байдалд дүгнэлт зөвлөмж өгөх;

- Шалгуур:** а. НББ-ийн тухай хууль;
 б. ТБОНӨТ хууль;
 в. Төсвийн тухай хууль;
 г. Авто тээврийн тухай хууль;
 д. УСНББОУС, холбогдох дүрэм журам зааврууд.

Бодит нөхцөл байдал:

Тус газар нь 2018 онд нийт 273,073.8 мянган төгрөгийн санхүүжилт авахаас тайлант хугацаанд төсвөөс 265,015.3 мянган төгрөгийн санхүүжилт авч 8,058.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Үзүүлэлт	Зардлын задаргаа		/төгрөг/
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	188,532,700	180,475,743	8,056,957
Гэрэл цахилгаан	2,176,000	2,176,000	-
Байрны түрээс	24,455,000	24,455,000	-
Бичиг хэрэг	3,500,000	3,500,000	-
Тээвэр шатахуун	2,794,100	2,794,000	100
Шуудан холбоо, интернэтийн төлбөр	3,000,000	2,999,672	328
Хог хаягдал зайлуулах хортон мэрэгчдийн устгал, ариутгал	258,000	258,000	-
Бага үнэтэй түргэн элэгдэх аж ахуйн эд зүйлс	500,000	500,000	-
Дотоод албан томилолт	1,000,000	1,000,000	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,660,000	43,660,000	-
Тээврийн хэрэгслийн татвар	48,000	48,000	-
Тээврийн хэрэгслийн оношлогоо	150,000	150,000	-
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000	2,998,900	1,100
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	1,000,000	1,000,000	-
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	274,073,800.00	266,015,315.00	8,058,485

Тус байгууллагын тухайн жилийн хэмнэлт нь цалин хөдөлмөрийн хөлснөөс буюу нэмэгдэл урамшлаас үүссэн байна.

Цалингийн зардлын хувьд 14 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулж тэдгээрт холбогдох нэмэгдэл урамшил, тэтгэмжийг олгон ажиллажээ.

Тус байгууллага 2018 оны 01 сарын 02-ны өдрийн 2018/001 дугаартай гэрээг "Тогосын хөндий" ХХК-тай байгуулж 120м² 2 өрөө талбайг 1м²-ийг 8000 төгрөг буюу нийтдээ 961,300 төгрөгөөр түрээсэлсэн, мөн 2017 оны 05 сарын 10-ны өдөр

Зорилт 3.1.3. Төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа үйл ажиллагаа болон төсвийн санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашигтай байдалд дүгнэлт зөвлөмж өгөх;

- Шалгуур:** а. НББ-ийн тухай хууль;
 б. ТБОНӨТ хууль;
 в. Төсвийн тухай хууль;
 г. Авто тээврийн тухай хууль;
 д. УСНББОУС, холбогдох дүрэм журам зааврууд.

Бодит нөхцөл байдал:

Тус газар нь 2018 онд нийт 273,073.8 мянган төгрөгийн санхүүжилт авахаас тайлант хугацаанд төсвөөс 265,015.3 мянган төгрөгийн санхүүжилт авч 8,058.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Үзүүлэлт	Зардлын задаргаа		/төгрөг/
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	188,532,700	180,475,743	8,056,957
Гэрэл цахилгаан	2,176,000	2,176,000	-
Байрны түрээс	24,455,000	24,455,000	-
Бичиг хэрэг	3,500,000	3,500,000	-
Тээвэр шатахуун	2,794,100	2,794,000	100
Шуудан холбоо, интернэтийн төлбөр	3,000,000	2,999,672	328
Хог хаягдал зайлуулах хортон мэрэгчдийн устгал, ариутгал	258,000	258,000	-
Бага үнэтэй түргэн элэгдэх аж ахуйн эд зүйлс	500,000	500,000	-
Дотоод албан томилолт	1,000,000	1,000,000	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,660,000	43,660,000	-
Тээврийн хэрэгслийн татвар	48,000	48,000	-
Тээврийн хэрэгслийн оношлогоо	150,000	150,000	-
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000	2,998,900	1,100
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	1,000,000	1,000,000	-
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	274,073,800.00	266,015,315.00	8,058,485

Тус байгууллагын тухайн жилийн хэмнэлт нь цалин хөдөлмөрийн хөлснөөс буюу нэмэгдэл урамшлаас үүссэн байна.

Цалингийн зардлын хувьд 14 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулж тэдгээрт холбогдох нэмэгдэл урамшил, тэтгэмжийг олгон ажиллажээ.

Тус байгууллага 2018 оны 01 сарын 02-ны өдрийн 2018/001 дугаартай гэрээг "Тогосын хөндий" ХХК-тай байгуулж 120м² 2 өрөө талбайг 1м²-ийг 8000 төгрөг буюу нийтдээ 961,300 төгрөгөөр түрээсэлсэн, мөн 2017 оны 05 сарын 10-ны өдөр

БА/БТТГ/17-05/21 дугаартай гэрээг “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн Багануур дахь салбартай байгуулан 104.6м² талбайг 1м²-ийг 9600 төгрөгөөр нийтдээ 1,004,160 төгрөгөөр түрээсэлсэн.

Томилолтын зардлын хувьд Дагуул хотуудын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг туршлага судлуулахаар 14 ажилтанд замын зардал олгосон. Тухайн байгууллага нь тайлант хугацааны эцсээр өр, авлагагүй ажилласан байна.

Бусдаар гүйцэтгүүлсэн 43,660,000 төгрөгийн зардал гаргасан байна. Энэхүү зардлаас “Биотехнологийг хөгжүүлэх нь” сэдэвт 1,2,3,4 уулзалтыг зохион байгуулсан зардал, сангийн засвар, танилцуулгын материалын зардал, сэлбэг хэрэгслийн зардлыг тус тус гаргасан байна. Сэлбэг хэрэгсэлд Авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дэвтрийг хөтөлж ажилласан.

“Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх” 2,998,900 зардлаас “Шинэ санаагаа оюуны өмчөөр баталгаажуулж хөрөнгө болгоё” сэдэвт сургалт зохион байгуулж 16 байгуулгыг хамруулан ажлуулсан байна.

Шатахууны зардлын хувьд: Шатахуун зарцуулалтыг тооцохдоо жолоочийн замын хуудсыг хэрэглэж байгаа боловч тухайн хуудсын үндсэн үзүүлэлт болох спидометрийн заалтыг тусгаагүй байна.

Шалтгаан:

- “Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх” 2,998,900 зардлаас “Шинэ санаагаа оюуны өмчөөр баталгаажуулж хөрөнгө болгоё” сэдэвт сургалт зохион байгуулж 16 байгуулгыг хамруулсан байгаа нь зардал зориулалт бусаар зарцуулагдсан байна.
- Шатахууны зардлын хувьд авч үзвэл шатахуун зарцуулалтыг хийхдээ Жолоочийн замын хуудсыг хэрэглэж байгаа боловч тухайн хуудсын үндсэн үзүүлэлт болох спидометрийн заалтыг тусгаагүй байгаа нь төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах эрсдлийг бий болгосон байна.

Үр нөлөө:

- Зардал ангиллын дагуу биш буруу зарцуулах, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаал зөрчигдөх эрсдэл үүснэ.
- Зардал зөв бүртгэгдэхгүй төсвийн хөрөнгө үргүйтэх эрсдэл үүснэ.

3.2 ДҮГНЭЛТ

Байгууллагын дүрэмд парк байгуулах бэлтгэл ажлыг хангахаар үндсэн чиг үүргийн хүрээнд хөрөнгө оруулалт, зураг төсөл, хөгжлийн стратеги төлөвлөгөөг боловсруулан ажиллахаар тусгасныг биелүүлэн ажилласан байна. Дүрмийн зарим байгууллагын нэр нэршил, чиг үүрэг өөрөөр тусгагдсан, чиг үүргийг тодорхойлохдоо байгууллагын үйл ажиллагааг цаашид үргэлжлэх байдлаар тодорхойлоогүй байна. Даргын зөвлөл хөдөлмөрийн дотоод журамд заасан тухай бүр хуралддагүй, дотоод хяналт, шалгалтын комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлаагүй. Тус байгууллага “Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх” зардлыг зориулалтын дагуу зарцуулаагүй. Холбогдох санхүүгийн баримт маягтыг бүрэн гүйцэт, утга агуулгаар нь хөтлөөгүй. Худалдан авах ажиллагааг холбогдох журмын дагуу гүйцэтгээгүй байна.

3.3 ЗӨВЛӨМЖ

“Багануур үйлдвэрлэл технологийн парк” ОНӨТҮГ нь ын захирал, нягтлан бодогч нарт:

- Байгууллагын дүрмийг шинэчлэн батлуулах;
- Даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлийг хурал бүрээр хөтөлж хэвших;
- Дотоод хяналт, шалгалтын комиссыг шинэчлэн томилох;
- Холбогдох зардлыг зориулалтын дагуу зарцуулах;
- Санхүүгийн баримт материалыг холбогдох заавар журмын дагуу хөтөлж хэвших;
- Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;
- Хөрөнгийг зохих журмын дагуу бүртгэж авах.

Илэрсэн асуудал бүрээр өгсөн зөвлөмжийн дагуу хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийн тайланг Нийслэлийн Дотоод аудитын газарт хугацаандаа ирүүлэхийг мэдэгдэж байна.

ТАНИЛЦСАН:

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН

ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ХЯНАСАН:



Я.САРАНСҮХ

ГҮЙЦЭТГЭЛ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,
СХШ-ЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

Г.ШҮРЭНЦЭЦЭГ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН /АХЛАХ АУДИТОР/,
СХШ-ЫН УЛСЫН БАЙЦААГЧ
МЭРГЭЖИЛТЭН /АУДИТОР/

Б.МЯГМАРЗАЯА
Б.СОЛОНГОЖАРГАЛ

ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН:

“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ,
ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН ДАРГА
НЯГТЛАН БОДОГЧ



Ч.ЭЛБЭГСАЙХАН

Л.ОЮУНЦЭЦЭГ

**НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН ГАЗАР
АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДЛЫН ЖАГСААЛТ**

Ажлын баримт: 3003/16

2019 оны 07 дугаар сарын 08

Аудит хийгдсэн нэгж:

Багануур үйлдвэрлэл, технологийн парк

Дотоод аудитын нэгж: Гүйцэтгэл, нийцлийн аудитын хэлтэс

Дд	Илэрсэн асуудлууд	Дүн	Зөвлөмж
1	2	3	4
ЗОРИЛТ 1:			
1	Байгууллагын дүрэмд зарим байгууллагын нэр нэршил, чиг үүрэг өөрөөр тусгагдсан, газрын чиг үүргийг тодорхойлохдоо үйл ажиллагааг цаашид үргэлжлэх байдлаар тодорхойлоогүй байна.		Байгууллагын дүрмийг шинэчлэн батлуулах
2	Даргын зөвлөлийг хөдөлмөрийн дотоод журамд зааснаар тухай бүр хуралдуулж байх		Даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлийг хурал бүрээр хөтөлж хэвших
3	Дотоод хяналт, шалгалтын комиссын бүрэлдэхүүнийг 2015 оны Б/112 тушаалаар баталсан, албан тушаалын нэршил өөрчлөгдсөн ч бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж шинэчлэн томилоогүй байна		Комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох
ЗОРИЛТ 2:			
5	Тус байгууллага 4,962,660 төгрөгөөр эргэлтийн цэг суулгаж тэмдэгжүүлсэн байна. Тус ажлыг "Тогосын хөндий" ХХК-аар гүйцэтгүүлж ажилласан боловч тэмдэг тэмдэглэгээг хөрөнгөөр бүртгээгүй, гэрээ байгуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; НББ-ийн тухай хуулийн 5.1.4. "үнэн зөв байх"; Төсвийн тухай хуулийн 6.3.2."санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах" гэсэн заалтуудын хэрэгжилт хангалтгүй байна.	4962.7	НББ-ийн тухай хуулийн 5.1.4, 6.3.2-ийг мөрдөж ажиллах.
6	Тус байгууллага 2018 онд "Тогосын хөндий" ХХК-аар нийт 19,114,960 төгрөгийн бараа, ажил үйлчилгээ гүйцэтгүүлж төлбөрийг шилжүүлсэн байна. Энэ нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 8.1.2.-т "...шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"; 8.7.1.-т "төндөр шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгох" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.	19,114.9	ТБОНӨХБАУХА тухай хуулийн 8.1.2, 8.7.1-ийг мөрдөж ажиллах.
ЗОРИЛТ 3:			
7	"Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх" 2,998,900 зардлаас "Шинэ санаагаа оюуны өмчөөр баталгаажуулж хөрөнгө болгоё" сэдэвт сургалт зохион байгуулж 16 байгуулгыг хамруулсан байгаа нь зардал зориулалт бусаар зарцуулагдсан байна.	2,998.9	Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалыг мөрдөж ажиллах.
8	Шатахууны зардлын хувьд авч үзвэл шатахуун зарцуулалтыг хийхдээ Жолоочийн замын хуудас маягтыг мөрдөж байгаа боловч тухайн маягтын үндсэн үзүүлэлт болох спидометрийн заалтыг тусгаагүй байгаа нь төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах эрсдлийг бий болгосон байна.	2,794.0	Төсвийн тухай хуулийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" заалтыг мөрдөж ажиллах.
		Дүн	29,870.5

АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДЛЫГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН:

Дарга

Ахлах нягтлан бодогч

Тэмдэг

Ч.Элбэгсайхан

Л.Оюунцэцэг

